# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аудитын нэр:* **"Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдал"-д хийх нийцлийн аудит**

**ХӨА-2018/01/-НА**

*Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэсэн нийцлийн аудитын тайлан*

## Төрийн албан хаагчдад олгож буй мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжид тавих хяналт хангалтгүй байна.

**Хөвсгөл аймаг**
**Мөрөн сум**
**2018 он**

**Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг**



**1. Төрийн жинхэнэ албан хаагч**

- Төрийн албаны тухай хуулийн 30.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолд тус тус заасны дагуу сүүлийн 3 жилийн нэг сарын үндсэн цалингийн дунджийг төрд ажилласан жилийн тоогоор үржүүлэн олгоно.

**2. Эрүүл мэндийн байгууллагын албан хаагч**

- Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу олгоно

**3. Боловсролын байгууллагын албан хаагч**

- Боловсролын тухай хуулийн 43.1.4 дэх заалт, 43.5 дахь хэсэгт заасны дагуу боловсролын байгууллагад 25 жилээс дээш ажилласан тохиолдолд сүүлийн 3 жилийн нэг сарын үндсэн цалингийн дунджийг төрд ажилласан жилийн тоогоор үржүүлэн олгоно.
- Боловсролын байгууллагад ажилласан жил нь 25 жилд хүрээгүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1 дэх хэсэгт заасны дагуу 1 сараас дээш хугацаагаар Засгийн газрын баталсан журмын дагуу олгоно.

**Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад олгох мөнгөн тэтгэмжийг**



1. **Боловсролын байгууллагын албан хаагч**
   - Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалтын дагуу 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгоно.
2. **Эрүүл мэндийн байгууллагын албан хаагч**
   - Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасны дагуу 3 болон 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгоно.

**Тайланг бэлтгэсэн:**

**Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газар**

ХӨА-2018/01/-НА

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор
О.Ганболд

Аудитын менежер
Ж.Отгончимэг

Ахлах аудитор
Л.Энх-Амгалан

Аудитор
Э.Бат-Эрдэнэ
С.Гансүх

**2018 оны 11 дүгээр сар**

**Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. www.audit.mn**

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу?
***ХАЯГ***: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр 3 давхарт)

**АГУУЛГА**

- Товчилсон үгийн жагсаалт 2
- Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээлэл 3-5

***Ерөнхий зүйл***

**БҮЛЭГ-1. Төсвийн төслийг боловсруулахдаа нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндэслэлгүй төлөвлөж, санхүүжүүлсэн байна.** 5-8

**БҮЛЭГ-2 Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 хэсэг, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалтад тус тус заасан шалгууруудыг хангаагүй төрийн албан хаагчдад тэтгэмж, тусламж олгосон байна.** 8-10

**БҮЛЭГ-3 Төрийн албан хаагчдад олгож буй нэг удаагийн тэтгэмжийн төлөвлөлт, олголтод тавих дотоод хяналт хангалтгүй байна.** 11-12

Дүгнэлт............................................
Зөвлөмж...............................................

Зөрчлийн жагсаалт.............................
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
Хавсралт ............................................
Тэргүүлэх аудиторын тушаал .............

**Товчилсон үгийн жагсаалт**

| Товчилсон үг | Тайлбар |
|---|---|
| **АДБОУС** | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| **ҮАГ** | Үндэсний аудитын газар |
| **НАГ** | Нийцлийн аудитын газар |
| **ХӨА** | Хөвсгөл аймаг |
| **НА** | Нийцлийн аудит |
| **ИТХ** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| **АТЕЗ** | Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч |
| **ЗДТГ** | Засаг даргын тамгын газар |
| **СТСХ** | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| **БСУГ** | Боловсрол, соёл, урлагийн газар |
| **ЭМГ** | Эрүүл мэндийн газар |
| **ЕБС** | Ерөнхий боловсролын сургууль |
| **СӨБ** | Сургуулийн өмнөх боловсрол |
| **ЭМТ** | Эрүүл мэндийн төв |
| **СДЭ** | Сум дундын эмнэлэг |
| **НДШ** | Нийгмийн даатгалын шимтгэл |

## 1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

## 2. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандартын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн төрийн албан хаагчдын 2016 он, 2017 оны нэг удаагийн мөнгөн тэтгэмж олголттой холбоотой санхүүгийн үйл ажиллагааг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. **Үүнд:**

- Төрийн албан хаагчдад олгох тэтгэмжийг хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, санхүүжүүлсэн эсэх
- Төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийг хууль, журмын дагуу тооцож олгосон эсэх
- Тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд дотоод хяналтыг хуульд зааснаар бүрэн хэрэгжүүлсэн эсэх

Аудитад Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар, аймаг, сумдын ЗДТГ, ЕБС, СӨБ, Соёлын төв болон холбогдох төсвийн байгууллагуудыг хамруулан төрийн албан хаагчдад 2016, 2017 онд олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэл, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэл, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлан гүйцэтгэв.

## 3. Аудитын арга зүй

Аудитад Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 400, 4000, 4100, Төрийн аудитын тухай хууль, нийцлийн аудитын арга зүйг ашиглан аймгийн ЗДТГ-ын СТСХ, ЭМГ, БСУГ, холбогдох төсвийн байгууллагын удирдлага, албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, судалгаа тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

## 4. Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. **Үүнд:**

- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль

- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийн тухай хууль
- МУ-ын дээд шүүхийн 2007 оны 05 дугаар тогтоол
- Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоол
- Засгийн газрын 2015 оны 338 дугаар тогтоол
- Бусад хууль, эрхийн актууд

## 5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Ганболд удирдаж, явцын болон үе шатны хяналтыг аудитын менежер Г.Эрдэнэчимэг, тайлагналын шатны хяналтыг аудитын менежер Ж.Отгончимэг нар тус тус хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Энх-амгалан, аудитор Э.Бат-Эрдэнэ, С.Гансүх нар 2018 оны 6 дугаар сарын 05-аас 2018 оны 11 дүгээр сарын 02-ны хооронд хооронд гүйцэтгэв.

## 6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь аудитын зорилтууд, хамрах хүрээ, арга зүй, тайлангийн хураангуй, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

## 7. Үндсэн мэдээлэл

Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголт 2016 онд нийт 3,228.6 сая төгрөг, 2017 онд 4,317.2 сая төгрөг байна. Ээлжит сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн улс төрийн албан тушаалтанд 2017 онд 368.0 сая төгрөгийн мөнгөн тэтгэлэг олгосон байна.

**Тэтгэмжийг нэр төрлөөр тооцвол:**

- Өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж

/Сая.төг/

| № | Огноо | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | 2016 он | 1,682,5 | 1,680,2 | -2.3 |
| 2 | 2017 он | 1,187.4 | 1,187.4 | 0 |
| Нийт дүн | | 2,869.9 | 2,867.6 | -2.3 |

- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж:

/Сая.төг/

| № | Огноо | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | 2016 он | 1,552.2 | 1,548.4 | -3.8 |
| 2 | 2017 он | 3,209.8 | 3,129.8 | -80.0 |
| Нийт дүн | | 4,762.0 | 4,678.2 | -83.8 |

# Бүлэг 1: Төсвийн төслийг боловсруулахдаа нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндэслэлгүй төлөвлөж, санхүүжүүлсэн байна.

## 1.1 Төрийн албан хаагчийн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламж олголттой холбоотой судалгаа, нэгдсэн бүртгэлийн сангийн тоон мэдээлэл зөрүүтэй байна.

Төрийн албан хаагчдын тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламж олголттой холбоотой судалгаа, нэгдсэн бүртгэлийн санг үнэн зөв боловсруулаагүй, байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн нэгтгэж, төсвийн төсөл боловсруулж байна. Үүнд:

- Аймгийн Эрүүл мэндийн газар, БСУГ-т төрийн албан хаагчдын нэг удаагийн тэтгэмж авсан нэгдсэн мэдээллийн сан[1] бүрдүүлсэн ч тус сан нь бодитой биш байна. Тэтгэмж аваагүй хүний мэдээлэл бүртгэгдсэн, мэдээллийг орхигдуулсан, давхардуулсан байна. Мэдээллийн санд давхардаж бүртгэгдсэн 24 хүний 66.2 сая төгрөгийн зөрчлийг *хүснэгт-1* ээр харуулбал:

*Хүснэгт 1: Мэдээллийн санд давхар бүртгэгдсэн жагсаалт* */мян. төг/*

| № | Сумын нэр | Байгууллагын төрөл | Тэтгэмж авах хүний тоо | Мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| | Давхардсан | | | |
| 1 | Мөрөн | ЕБСургууль | 4 | 10,973.0 |
| 2 | Хатгал | | 1 | 2,100.9 |
| 3 | Баянзүрх | | 3 | 9,220.4 |
| 4 | Цагаан-Уул | | 1 | 3,174.5 |
| 5 | Арбулаг | | 1 | 3,211.7 |
| 6 | Цагааннуур | | 1 | 1,971.0 |
| 7 | Жаргалант | | 5 | 13,495.7 |
| **8** | Рашаант | | 8 | 21,980.9 |
| **Нийт дүн** | | | **24** | **66,128.1** |

## 1.2 Нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламжийн зардлыг үндэслэлгүй төлөвлөж, санхүүжүүлсэн байна.

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дах хэсгийн дагуу олгох мөнгөн тэтгэмжийг мэдээ, судалгаанд үндэслэлгүй төлөвлөснөөс тэтгэмж авсан огноонууд хуульд заасан хугацаанаас /3 жил, 5 жил тутам/ зөрүүтэй байна. Үүнд:

[1] *Эрүүл мэндийн тухай хууль 25.18.Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан нь эмнэлгийн мэргэжилтний бүртгэлд орсон он, сар, өдөр, мэргэжил, мэргэшил, төгсөлтийн дараахь сургалтад хамрагдсан байдал, мэргэшлийн зэрэг, ажиллаж байсан болон ажиллаж байгаа байгууллага, эрхэлж байгаа албан тушаалын талаархи мэдээллийг агуулах бөгөөд жил тутам шинэчлэгдэж байна.*

- Боловсролын байгууллагын 26 ажилтанд нийт 83.0 сая төгрөгийг 2019 онд олгох ёстой боловч 2018 онд олгохоор төлөвлөсөн байна. *(Хүснэгт 2-оос харна уу)*

*Хүснэгт 2 : Ажилласан жилийг үндэслэлгүй тооцоолж, төлөвлөсөн байгууллагын жагсаалт /мян. төг/*

| № | Сумын нэр | Тэтгэмж авагчийн тоо | Мөнгөн дүн | Огноо |
|---|---|---|---|---|
| 1 | Баянзүрх сум | 2 | 6,617.6 | 2018 |
| 2 | Галт | 1 | 3,237.0 | 2018 |
| 3 | Жаргалант | 6 | 20,276.4 | 2018 |
| 4 | Мөрөн | 1 | 2,517.1 | 2018 |
| 5 | Рашаант | 6 | 18,355.4 | 2018 |
| 6 | Тариалан | 3 | 9,746.5 | 2018 |
| 7 | Хатгал | 2 | 5,819.7 | 2018 |
| 8 | Цагаан-Уул | 2 | 6,530.6 | 2018 |
| 9 | Шинэ-Идэр | 2 | 6,760.8 | 2018 |
| 10 | Эрдмийн далай | 1 | 3,237.0 | 2018 |
| | **Нийт дүн** | **26** | **83,098.1** | |

- Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтанд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг хуульд заасан хугацаанаас /3 жил, 5 жил тутам/ зөрүүтэй тооцсоноор нийт 35.7 сая төгрөгийн тэтгэмж, үүнээс 23.1 сая төгрөгийн тэтгэмжийг хугацаанаас нь өмнө олгохоор төлөвлөсөн байна. *(Хүснэгт 3-аас харна уу)*

- Эрүүл мэндийн салбараас өндөр насны тэтгэвэрт гарсан иргэдэд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 1 ба түүнээс дээш жилийн дараа олгосон байна.
  **Тухайлбал:**Улаан-Уул сумын СДЭ-ийн үйлчлэгч Д.Дулмаа 2013 онд өндөр насны тэтгэвэрт гарсан боловч тэтгэмж /6.5 сая төгрөг/-ийг 2017 онд олгосон байна.

*Хүснэгт 3: Ажилласан жилийг үндэслэлгүй тооцоолж, төлөвлөсөн байгууллагын жагсаалт /мян. төг/*

| № | Сум, өрхийн ЭМТ-ийн нэр | Эмч, эмнэлгийн ажилтны тоо | Мөнгөн дүн | Үүнээс | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Шалгуур хангаагүй | Орхигдуулсан |
| **1** | Нэгдсэн эмнэлэг | 8 | 23,868.9 | 14,475.1 | 9,393.8 |
| **2** | Рэнчинхүмбэ ЭМТ | 1 | 2,797.7 | 2,797.7 | 0.0 |
| **3** | Галт сумын ЭМТ | 1 | 3,111.1 | 3,111.1 | 0.0 |
| **4** | Тариалан сумын ЭМТ | 1 | 3,135.3 | 0.0 | 3,135.3 |
| **5** | Цэцэрлэг сумын ЭМТ | 1 | 2,797.7 | 2,797.7 | 0.0 |
| | **Нийт** | **12** | **35,710.8** | **23,181.7** | **12,529.1** |

- Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3[2] дах заалтыг Засгийн газар зохицуулаагүйгээс төрийн үйлчилгээний албан

[2] *Төсвийн байгууллагаас энэ хуулийн 42.1-д заасан нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан нийтлэг журмыг Засгийн газар батална.*

тушаалтанд олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг харилцан адилгүй олгохоор төлөвлөж байна. Энэ талаар ҮАГ-т санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 1.3 Холбогдох судалгаа хийхгүйгээр төсвийн төслийг төлөвлөж, жилийн дундуур тодотгол хийсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлыг хянахгүй, байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэн, орон нутгийн төсвийн төсөл бэлтгэж АИТХ-д оруулж байна. Тухайн жилд шаардагдах төсвийг бүрэн төлөвлөөгүйгээс тодотгол хийх, нөхөж олгох замаар шийдвэрлэж байна.

Нэг удаагийн тэтгэмжийн зардлыг дутуу төлөвлөснөөс 2017 онд 149.9 сая төгрөгийг нэмж тодотгосон байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38.1[3] хэсэгт заасныг үндэслэн ээлжит сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад 2017 онд 6 сарын тэтгэмжийг бүрэн олгоогүй байна.

Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн 117 улс төрийн албан тушаалтанд 422.8 сая төгрөгийн тэтгэмж олгохоор тооцож, саналыг Сангийн яаманд хүргүүлснээс 104 улс төрийн албан тушаалтны 368.0 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгохоор хянасан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38.1 дэх заалтыг зохицуулсан, дагаж мөрдөх журамгүй, сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох тэтгэмжийн талаар тодорхой заагаагүйгээс дараах нөхцөл үүссэн байна. **Үүнд:**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн өргөдлийн дагуу аудит хийж, сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн Жаргалант сумын ИТХ-ын дарга Б.Должинсорогдог, Засаг даргын орлогч Д.Амарбаясгалан нарт олгосон мөнгөн тэтгэмжийн **8.1** сая төгрөгт төлбөрийн акт тогтоосныг хариуцагч Б.Должинсорогдог, Б.Амарбаясгалан нар хүлээн зөвшөөрөөгүй байна. Иймд сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн ТАХ-д олгосон мөнгөн тэтгэмжийг хэрхэн шийдвэрлэхийг тодруулахаар ҮАГ-т хүргүүлсэн болно.

[3] *38.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.*

# Бүлэг 2: Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дах заалтад тус тус заасан шалгуурыг хангаагүй төрийн албан хаагчдад тэтгэмж, тусламж олгосон байна.

## 2.1 Зарим төрийн албан хаагчдын ажилласан хугацааг үндэслэлтэй тооцоогүй байна.

Орон нутгийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн байгууллагуудын хувьд өндөр насны тэтгэвэрт гарсан төрийн албан хаагчдын төрийн албанд ажилласан жилийг хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, шүүхээр тогтоолгосон жил зэрэг баримтаар тооцсон хугацааг шалгахад зөрүүгүй байна.

Боловсрол, эрүүл мэндийн байгууллагын хувьд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан зарим албан хаагчдын ажилласан жилийг үндэслэлгүй тооцсон, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дах хэсэгт заасан шалгуур хангаагүй төрийн албан хаагчдад мөнгөн тэтгэмж олгосон байна. (*Тайлангийн 2.2 хэсэгт харуулав.*)

## 2.2. Мөнгөн тэтгэмжийг үндэслэлгүй тооцож, олгосон байна.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан Боловсролын болон Эрүүл мэндийн байгууллагуудын ажилтнуудад олгосон төрөөс үзүүлэх дэмжлэг, мөнгөн тэтгэмж олголтыг шалгахад дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

- Боловсрол, эрүүл мэндийн байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан зарим албан хаагчдын ажилласан жилийг үндэслэлгүй тооцсон, шалгуур хангаагүй төрийн албан хаагчдад мөнгөн тэтгэмж олгосон зөрчил байна. **Тухайлбал:**
- 2012 онд: Галт сумын ЕБС-ийн дотуур байрын багш М.Батсайхан /1.8 сая төгрөг/, М.Оюунгэрэл /1.8 сая төгрөг/ нарт Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-ийн 43.1.7.а[4] дахь заалтыг зөрчин нийт 3.6 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.(*Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.)*
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад олгох мөнгөн тэтгэмжийг 9 ажилтанд 1.2 сая төгрөгөөр дутуу олгосон байна. (*Хүснэгт 6- аас харна уу)*

[4] *(...сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, **дотуур байрны багш**, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч; ...)*

*Хүснэгт 6: Байгууллагын жагсаалт* */мян. төгрөг/*

| № | Байгууллагын нэр | Олгосон мөнгөн дүн | Эмч, эмнэлгийн ажилтны тоо | Байгууллагаас ирүүлсэн цалингийн тодорхойлолтоор | Дутуу олгосон |
|---|---|---|---|---|---|
| 1 | Галт ЭМТ | 6,361.5 | 2 | 6,687.5 | -174.4 |
| 2 | Их-Уул СДЭ | 3,351.4 | 1 | 3,378.0 | -26.6 |
| 3 | Цэцэрлэг ЭМТ | 3,111.1 | 1 | 3,135.3 | -24.2 |
| 4 | Бүрэнтогтох ЭМТ | 2,818.8 | 1 | 3,159.9 | -341.1 |
| 5 | Нэгдсэн эмнэлэг | 3,135.3 | 1 | 3,378.0 | -242.7 |
| 6 | Энэрэл ӨЭМТ | 3,617.7 | 1 | 3,809.5 | -191.8 |
| 7 | Ханх ЭМТ | 6,249.4 | 2 | 6,319.8 | -48.8 |
| | **Нийт дүн** | **28,642.2** | **9** | **29,904.9** | **-1,262.6** |

- Хатгал тосгоны СӨБ-ийн няравт 42 жил ажилласантай нь холбогдуулан 42 сараар буюу 19.7 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 30.2[5] дахь хэсэгтэй нийцэхгүй байна.
- Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 заалт дахь заалтын дагуу олгох мөнгөн тэтгэмжийг үндэслэлгүй төлөвлөснөөс нийт 30 ажилтанд **79.3** сая төгрөгийг авбал зохих хугацаанд нь олгоогүй байна. Аудитын хугацаанд зөрчлийг залруулж ажилласан болно. (*Хүснэгт 5-аас харна уу*)

*Хүснэгт 5: Тэтгэмжийн хугацааг үндэслэлгүй тооцож олгосон байгууллагын жагсаалт* */мян.төг/*

| № | Сумын нэр | Боловсролын байгууллагын нэр | Багш ажилтны тоо | Мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Мөрөн | 1-р цэцэрлэг | 1 | 1,854.5 |
| 2 | Мөрөн | 2-р цэцэрлэг | 1 | 2,173.2 |
| 3 | Мөрөн | 10 цэцэрлэг | 1 | 3,467.0 |
| 4 | Алаг-Эрдэнэ | Цэцэрлэг | 1 | 4,045.5 |
| 5 | Галт | Сургууль | 2 | 4,786.0 |
| 6 | Галт | Цэцэрлэг | 5 | 13,783.7 |
| 7 | Жаргалант | Сургууль | 8 | 23,185.9 |
| 8 | Тосонцэнгэл | Сургууль | 3 | 9,203.9 |
| 9 | Хатгал | Цэцэрлэг | 2 | 4,346.4 |
| 10 | Цагааннуур | Сургууль | 3 | 6,854.6 |
| 11 | Цагаан-Үүр | Цэцэрлэг | 2 | 5,585.6 |
| 12 | Эрдэнэбулган | Сургууль | 1 | 3,466.9 |
| | **Нийт дүн** | | **30** | **79,286.0** |

- Нэгдсэн эмнэлгийн болон сумдын ЭМТ-ийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажилласан хугацааг бодитой тооцоогүйгээс 2017 онд 7 мэргэжилтэнд **23.2** сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Эрүүл

*[5] Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна.*

мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5[6] хэсэгтэй нийцэхгүй байна. *(Хүснэгт 3-аас харна уу)*

- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг ЭМГ-ын төсвийн данснаас олгосон нь мөн хуулийн 29.5 дах хэсэгтэй нийцэхгүй байна.
- Ханх сумын ЕБС-ийн багш Б.Содгэрэлд 5 жил тутамд олгох тэтгэмжийг хугацаанаас нь өмнө буюу 2016 онд **3.2** сая төгрөг олгосон, Тосонцэнгэл сумын ЕБС-ийн сургалтын менежер Ц.Пүрэвдоржид 2019 онд олгох **1.7** сая төгрөгийн тэтгэмжийг 2017 онд олгосон нь Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7[7] дахь заалттай тус тус нийцэхгүй байна. *(Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.)*

БСУГ-ын даргад зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг нийцлийн аудитаар хүргүүлэв.

### 2.3 Мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Баянзүрх сумын ЗДТГ нь 2.8 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас цалингийн зардалд зарцуулсан байна.

Бусад байгууллагуудын хувьд төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлыг өөр зүйлд зарцуулаагүй байна.

## Бүлэг 3: Төрийн албан хаагчдад олгож буй нэг удаагийн тэтгэмжийн төлөвлөлт, олголтод тавих дотоод хяналт хангалтгүй байна.

### 3.1 Төрийн албан хаагчдад олгосон мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зарцуулалтад хийсэн дотоод хяналт хангалтгүй байна.

Төрийн албан хаагчдад олгосон мөнгөн тэтгэмжийн зардлын гүйцэтгэлд хийсэн дотоод хяналт дараах байдалтай байна. Үүнд:

- Санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн шалгалтуудаар төрийн албан хаагчдад олгосон мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлын гүйцэтгэл, мөнгөн тэтгэмж, тусламжийн олголтод зөрчил илрүүлээгүй байна.

**Нийцлийн аудитаар илэрсэн 369.9 сая төгрөгийн зөрчлүүдээс харахад:** Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт хангалтгүй байна.

- Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тусламжаа авсан нэр

[6] *29.5.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.*

[7]

бүхий төрийн албан хаагчид боловсон хүчний дутагдлаас болж, албан үүргээ гүйцэтгэсээр байна. */Хүснэгт 7-гоос харна уу/*

*Хүснэгт 7: ЭМ-ийн тухай хуулийн дагуу дагуу өндөр насны тэтгэвэртээ гараад ажиллаж байгаа ажилтнуудын судалгаа*

| № | ЭМБ-ын нэр | Овог нэр | Албан тушаал | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Нэгдсэн эмнэлэг | Баярцэцэг | Эх барих эмэгтэйчүүдийн эмч | Боловсон хүчин дутагдалтай |
| 2 | Нэгдсэн эмнэлэг | Жаргалмаа | БЗХХ/ДОХ хариуцсан эмч | |
| 3 | Цагаан-Уул СДЭ | Ц.Булгаа | ЭМТ-ийн дарга | ЭМТөвийн даргын сонгон шалгаруулалт зарлахад орох эмч олддоггүй. Боловсон хүчний дутагдалтай. |
| 4 | Эрдэнэбулган СЭМТ | Д.Цолмон | ЭМТ-ийн дарга | |
| 5 | Бүрэнтогтох СЭМТ | Г.Баярхүү | ЭМТ-ийн дарга | |
| 6 | Төмөрбулаг СЭМТ | Ч.Цэцэгмаа | ЭМТ-ийн дарга | |
| 7 | Рэнчинлхүмбэ СЭМТ | Д.Сэлэнгэ | лаборант | Жирэмсэн хүний оронд түр ажиллаж байгаа |
| 8 | Энэрэл ӨЭМТ | Ж.Алтанцэцэг | ӨЭМТ-ийн дарга | Хувийн хэвшлийн байгууллага, томилох чөлөөлөх эрх зүй байхгүй. |
| 9 | ӨЭМТ | Д.Баясгалан | ӨЭМТ-ийн ня-бо | |
| 10 | Улаан-Уул СДЭ | Д.Наранцэцэг | Хүүхдийн эмч | Боловсон хүчин дутагдалтай |
| 11 | Арбулаг СЭМТ | Т.Цэцэгмаа | эх барих эмэгтэйчүүдийн эмч | Боловсон хүчин дутагдалтай |
| 12 | ЗӨСТ | Л.Норовсүрэн | ня-бо | Элэгний ВС вирусын өндөр өртөгтэй эм удаг эрүүл мэндийн шалтгаанаар даргатайгаа тохирсон. |

## 3.2 Төрийн албан хаагчдын тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжтай холбоотой гарсан зөрчилд арга хэмжээ аваагүй байна.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгосон мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн төлөвлөлт, олголттой холбоотой алдаа зөрчлийг илрүүлж, зохих хууль тогтоомжийн дагуу ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аудитаар нийт **369.9** сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс **119.9** сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, **11.6** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, **238.4** сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. **Үүнд:**

1. Төрийн албан хаагчдын тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн олголтод шаардагдах судалгаа, нэгдсэн бүртгэлийн сан дахь мэдээлэл бодит бус, төсвийг үнэн зөв, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс төсвийн жилийн дундуур тодотгол хийсэн, зохих хууль тогтоомжийн дагуу тооцож олгоогүй байна.
2. Бүрдүүлсэн материалыг хянахгүйгээр төрийн албан хаагчдад мөнгөн тэтгэмж олгохоор төлөвлөж, санхүүжүүлсэн, тэтгэмж олгосон хугацаа харилцан адилгүй байна.
3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн байгууллагаар дамжуулахгүй, Эрүүл мэндийн газрын төсвийн данснаас шууд олгосон байна.
4. Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тусламж авсан зарим төрийн албан хаагч тухайн мэргэжлийн боловсон хүчний нөөцийн дутагдлаас шалтгаалан албан үүргээ гүйцэтгэсээр байна.
5. Төрийн албан хаагчдад олгосон мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд хийсэн нийцлийн аудитаар нийт 369.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс харахад санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн хяналт хангалтгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. **Үүнд:**

**Аймгийн засаг дарга Л.Ганболдод:**

1. Орон нутгийн төсөв, мөнгөн тэтгэмжийн зардлыг үндэслэлтэй тооцож, холбогдох зардлыг бодитой төлөвлөж байх.
2. Боловсон хүчний нөөц бүрдүүлэхэд арга хэмжээ авч, өндөр насны тэтгэвэрт гарч байгаа албан тушаалтны ажлын байрны сул орон тоог нөөцөөс бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

**Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувдад:**

1. Төрийн албан хаагчдын мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн төлөвлөлт, олголтод тавих хяналтаа сайжруулж, гүйцэтгэлийг хангуулж ажиллах.

**Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Я.Дашзэвэгт:**

1. Төрийн албан хаагчдын тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн олголтод шаардагдах судалгаа, бүртгэлийн нэгдсэн санг үнэн зөв хөтөлж, АТЕЗ-ийг бодит мэдээллээр хангаж ажиллах.

2. Төрийн албан хаагчдад мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохдоо хууль, журамд заасан шалгуур хангасан эсэхийг бодитой тооцож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах.

**Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийн баярт:**

1. Төрийн албан хаагчдын тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн олголтод шаардагдах судалгаа, нэгдсэн санг ашиглаж, тэтгэмж олгох шалгуур хангасан төрийн албан хаагчдад мөнгөн тэтгэмжийн зардлыг бодитой төлөвлөж, олгож байх.
2. Өрх сум тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаар дамжуулан олгож байх.

**Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга В.Нэргүйд:**

1. Төрийн албан хаагчдад олгож байгаа мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн олголт, төлөвлөлтөд санхүүгийн хяналт, дотоод аудитыг үр дүнтэй гүйцэтгэж, АТЕЗ-ийн төсвийг эрсдэлээс хамгаалж ажиллах.

**Үндэсний аудитын газарт**

**Санал:**

1. *Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг “Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгох харилцаа-“г Засгийн газар зохицуулна гэсэн бөгөөд зохицуулсан эрхзүйн акт гаргаагүй байна.*
2. *Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38.1 дэх заалтыг зохицуулсан, дагаж мөрдөх журамгүй, сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох тэтгэмжийн талаар тодорхой заасан эрхзүйн ямар нэгэн зохицуулалт гараагүй байна.*

**Зөрчлийн жагсаалт**

*/Сая төгрөгөөр/*

| № | *Илэрсэн зөрчлийн* | | *Өгсөн албан шаардлага* | | *Тавьсан акт* | | *Өгсөн зөвлөмж* | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Утга | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| *1* | Эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд олгож байгаа мөнгөн тэтгэмжийг олгохдоо нэг сарын үндсэн цалинг үндэслэлгүй тооцож олгосон 1.2 сая, шалгуур хангаагүй ТАХ-д хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох 23.2 сая, 12.5 сая төгрөгийн тэтгэмжийг олгохоор төлөвлөсөн. | *36.9* | *1* | *36.9* | | | | |
| *2* | Эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд 0.3 сая төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон | *0.3* | | | *1* | *0.3* | | |
| *4* | Төсвийг шаардлагатай хөрөнгийн хэмжээгээр бүрэн төлөвлөөгүйгээс дараа жилийн төсөвт нэмж тооцох, төсвийн жилийн дундуур тодотгол хийж, 149.9 сая төгрөгийг нэмж тодотгосон байна. | *149.9* | | | | | *1* | *149.9* |
| *4* | 2013 онд өндөр насны тэтгэвэрт гарсан Улаан-Уул сумын СДЭ-д үйлчлэгч ажилтай Д.Дулмаагийн тэтгэмж /6.5 сая төгрөг/-ийг 2017 онд олгосон | *6.5* | | | | | *1* | *6.5* |
| *5* | Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалтын дагуу олгох мөнгөн тэтгэмжийг үндэслэлгүй төлөвлөснөөс нийт 30 ажилтанд 79,2 сая төгрөгийн тэтгэмжийг хугацаанаас нь өмнө олгосон байна. | *79.2* | | | | | *1* | *79.2* |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7.а заалт дахь албан тушаалтай */2014 онд тэтгэмж авсан/* 26 хүнд нийт 83.0 сая төгрөгийг 2018 онд олгохоор төлөвлөн төсөвт суулгасан | 83.0 | 1 | 83.0 | | | | |
| 7 | Хатгал тосгоны СӨБ-ийн няравт нэг удаагийн буцалтгүй тусламж олгосноос 2.8 сая төгрөгийг илүү олгосон байна. | 2.8 | | | 1 | 2.8 | | |
| 8 | Боловсролын тухай хуулийн 43.1.7 дахь заалтыг зөрчин Тосонцэнгэл сумын ЕБС-ийн сургалтын менежер Ц.Пүрэвдоржид 2019 онд олгох 1,706.9 мянган төгрөгийн тэтгэмжийг 2017 онд олгосон байна. | 1.7 | | | 1 | 1.7 | | |
| 9 | 2012 онд Галт сумын ЕБС-ийн дотуур байрын багш М.Батсайхан /1.8 сая төгрөг/, М.Оюунгэрэл /1.8 сая төгрөг/ нарт Боловсролын тухай хуулийн 43.1.7-ийн 43.1.7.а заалтыг зөрчиж тэтгэмж олгосон | 3.6 | | | 1 | 3.6 | | |
| 10 | Ханх сумын ЕБС-ийн сургалтын менежер Б.Содгэрэлд 2014 онд 3.2 сая төгрөг, 2016 онд 3.2 сая төгрөгийг тус тус олгосон байна. Үүнээс 3.2 сая төгрөг илүү олгогдсон байна. | 3.2 | | | 1 | 3.2 | | |
| 11 | Баянзүрх сумын ЗДТГ –ын төсөвт ТАХ –ийн ажилласан хугацааг тооцох үндсэн баримт бичигт үндэслэн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг тооцоогүй төсөв баталснаас 2017 оны 18.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөс хэмнэгдсэн 2,8 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан | 2.8 | | | | | 1 | 2.8 |
| 12 | БСУГ, ЭМГ-д хариуцлага тооцох санал хүргүүлэв. | | 2 | | | | | |
| **Нийт** | | **369.9** | **4** | **119.9** | **5** | **11.6** | **4** | **238.4** |

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛ

| Саналтай холбоотой тайлбар | Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал |
|---|---|
| | МОНГОЛ УЛС<br>ХӨВСГӨЛ АЙМГИЙН<br>ЗАСАГ ДАРГА<br>67123 Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уран дөш баг<br>Утас: 70382300, факс: 70381001<br>www.khovsgol.gov.mn<br>2018.11.12 № 1/2477<br>танай ______ -ны № ______<br><br>АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН<br>ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР<br>О.ГАНБОЛД ТАНАА<br><br>Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдалд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд холбогдох саналыг хүргүүлж байна.<br><br>Хавсралт ..13.. хуудастай.<br><br>ДАРГА Л.ГАНБОЛД<br><br>ХҮЛЭЭН АВСАН 2018 он 11 сар 12 |

***Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдалд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд хүргүүлэх санал.***

**БҮЛЭГ 1.**

**1.2. Тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлыг холбогдох байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд хяналтгүй төлөвлөж байна.**

Санал-1

*Хүлээж авах боломжгүй байна.*

- **Орон нутгийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан тушаалын ажилтанд олгож байгаа нэг удаагийн тусламжийг өөр өөр хугацаагаар төлөвлөж байна ...**

Тайлбар: Саналын 4 дэх хэсэгт “Орон нутгийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан тушаалын ажилтанд” ... гэж тодорхойлсон хэрнээ ТЗШ-ийн байгууллагуудаас тэтгэмж авсан хүмүүсийн мэдээлэл бичсэн, мөн үүнтэй хамаарах хавсралт 5 нь ОН-ийн байгууллагуудаас тэтгэвэрт гарсан хүмүүсийн мэдээлэл байгаа нь ойлгомжгүй байна. Хавсралт 5-д дурдагдсан хүмүүсээс 2017 онд тэтгэвэрт гарсан ТҮ-ний ажилтан байсан нэг хүний мэдээлэл байгаа бөгөөд Сангийн яамнаас хянаж батлахдаа улсын төсөв ихээхэн хүндрэлтэй байгаа шалтгаанаар тэтгэмж тооцох хугацааг 6 сараар тооцсон байна. СТСХ-ээс яаманд хүргэсэн санал нь 12 сараар байсан.

Санал-2

*Хүлээж авах боломжгүй байна.*

Бусад нь 2018 онд тэтгэвэрт гарч байгаа хүмүүсийн мэдээлэл байгаа бөгөөд тэтгэмж тооцсон сарыг байгууллагуудаас ирсэн саналаар тусгаж харуулсан буюу 18, 12, 19 гэх мэт өөр өөр байна. Харин Сангийн яамнаас хянаж баталсан, тэтгэмж тооцох хугацаа нь 12-оор байгаа тул “нэг удаагийн тэтгэмжийн зардлыг хяналтгүй төлөвлөж байна” гэдэгтэй санал нийлэхгүй байна.

Сангийн яамнаас “Төрийн захиргааны байгууллагаас тэтгэвэрт гарч байгаа ТҮ-ний ажилтанд олгох тэтгэмж тооцох хугацааг зохицуулах журам” боловсруулж засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байгаа гэдэг мэдээллийг өгсөн.

- **Тэтгэмжийн зардлыг шаардлагатай хэмжээгээр бүрэн төлөвлөөгүйгээс дараа жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэж байна. АИТХ-ын 2017 оны ээлжит бус 14 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолоор 149,9 сая төгрөг нэмж баталсан...**

Тайлбар: Тогтоолын тухайд 2016 оны 4 дүгээр сард батлагдсан тогтоол байна. 2016 онд тэтгэвэрт гарах албан хаагчдын тэтгэмжийн зардлын 2015 оны 8 дугаар сард хянуулсан бөгөөд хянагдсан 324,9 сая төгрөгийн 63%-тай тэнцэх буюу 206,3 сая төгрөг 11 сард батлагдан ирсэн. Сангийн яамнаас ирсэн чиглэлд энэ тухай тодорхой тусгасан байна. /хавсаргав/

Мөн Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоол буюу “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын дагуу тусламж авах албан хаагчдын тэтгэмжийн дутууг мөн үүгээр шийдвэрлэсэн байсан.

2015 оны давсан орлого, дансны үлдэгдэл зарцуулах шийдвэрийг дээр дурдсан АИТХ-ын 2017 оны ээлжит бус 14 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд тэтгэвэрт гарч байгаа албан хаагчдын тэтгэмжийг бүрэн олгож барагдуулах бодлогыг хэлтсийн зүгээс барьж тэтгэмжийн дутууг нөхөн олгосон. Харин Сангийн яамнаас 2016 оны төсөвт батлагдах байсан тэтгэмжийн дутуу төсвийг 2017 оны төсөв батлагдан ирэх үед нэмэгдүүлэн тооцож ирүүлснийг зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай зардлуудад хуваарилан зарцуулсан болно. Иймд “тэтгэмж олгох шалгуур хангаагүй төрийн албан

| | |
|---|---|
| Санал-3<br><br>*Тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй*<br><br><br><br><br><br><br><br><br><br>Санал-4<br><br>*Тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй* | хаагчдад мөнгөн тэтгэмж олгохоор тооцсоноос үүссэн зөрүүг тодотголоор шийдвэрлэсэн” гэдэг саналыг хүлээж авах боломжгүй байгаа тул ирүүлсэн саналаа эргэж харахыг хүсье.<br><br>• **Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгосон тэтгэмжийн тухай**<br><br>Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно гэж заасан бөгөөд эргэж ажилтай болсон тохиолдолд хэрхэн шийдвэрлэх тухай тодорхой заасан зүйлгүй байгаа юм.<br><br>Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмжийн талаарх судалгааг Сангийн яамнаас 2017 оны 1 дүгээр сард тусгай бэлтгэсэн маягтаар авсан бөгөөд үүнд нь ажилтай болсон эсэх гэсэн хэсэг байсан. Маягтыг бүх сумдад хүргэн судалгааг гаргуулан авч нэгтгэн Сангийн яаманд хугацаанд нь хүргэсэн.<br><br>Судалгааг нэгтгэхэд нийт 117 хүнд олгогдох 422,8 сая төгрөгийн тэтгэмжийн тооцоо гарсан бөгөөд энэ дүнгээр нь яаманд хүргэсэн. 117 хүний 14 нь эргэж ажилтай болсон бусад нь ажил хөдөлмөр эрхлээгүй гэдэг мэдээллийг ирүүлсэн. Уг тэтгэмжийг 2017 оны эцэст “эргэж ажилтай болсон” гэх тайлбартай хүмүүсийг хасч тооцон бусад хүмүүст нь олгогдох 368,0 сая төгрөгийг төсвийн тодотголоор баталж ирүүлсэн бөгөөд сум, байгууллага бүрт нь хуваарилан хүргэж олгосон.<br><br>Эргэж ажилтай болсон хүнд олгохгүй гэх үндэслэл холбогдох хууль журмаар зохицуулагдаагүй тул олгогдох ёстой тэтгэмжийн зөрүүг нэмж шийдүүлэх асуудлыг Сангийн яаманд тавьсан бөгөөд яамнаас анхааран үзэж зөрүү 54,8 сая төгрөгийг 2019 оны төсөвт шийдэж өгөх болсон. Уг 54,8 сая төгрөгийг батлагдан ирэхэд “эргэж ажилтай болсон” гэх шалтгаанаар тэтгэмж аваагүй байгаа албан хаагчдад хуваарилан олгох бөгөөд тайлангийн төсөлд нэр дурдагдсан Б.Должинсоргодог, Д.Амарбаясгалан нар үүнд багтаж байгаа болно.<br><br>**БҮЛЭГ 2.**<br><br>**2.3. Мөнгөн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.**<br><br>Баянзүрх сумын ЗДТГ-аас 2017 онд тэтгэвэрт гарсан С.Эрдэнэцэцэгийн тэтгэмжийн тухайд сумаас болон хэлстээс хянаж Сангийн яаманд хүргүүлсэн ажилласан жилийн тооцоо нь 15 жилээр байгаа бөгөөд харин яамнаас хянахдаа 23 жилээр тооцож төсвийг баталж ирүүлсэн. Нэгэнт батлагдаж ирсэн төсвийг байгууллагад нь хүргүүлсэн бөгөөд байгууллага нь өмнө нь тооцож байснаараа 15 жилээр бодож тэтгэмжийг олгосон байна. Сангийн яаманд хүргэж байсан санал болон хянагдсан тооцоог хавсралтаар хүргэлээ. /3 хуудас/<br><br>**БҮЛЭГ 3:**<br><br>**Төрийн албан хаагчдад олгож буй нэг удаагийн тэтгэмжийн төлөвлөлтөд тавих дотоод хяналт хангалтгүй байна.**<br><br>**“Төрийн жинхэнэ албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 10 дахь хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэврээ албан ёсоор тогтоолгосон эсэхийг төрийн сан хянаагүй, нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон байна.** |

| | |
|---|---|
| Санал-5<br><br>*Тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй* | Засгийн газрын 2014 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.8-д Тухайн байгууллага нь төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна гэж заагдсан.<br><br>Мөн тус журмын 3.6 Төрийн сан төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтэн дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад 1 хувийг өгнө гэж заагдсан. Дээрх заалтуудын дагуу төлбөрийн хүсэлт хяналтыг хуудсыг баримттай тулгаж ажиллаж байна.<br><br>Тайлбар бичсэн:<br>СТСХ-ийн мэргэжилтэн Г.Базар<br>Б.Цэлмэгтуяа |

Санал-6

*Тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй*

ХОВСГОЛ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗАР

67125, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Элст баг
Багшийн хөгжлийн ордон. Утас: 7038 3693
Э-мэйл: khuvsgul@mecs.gov.mn

2018-11-12 № 363

танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ГАНБОЛД ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тугаал, аймгийн Аудитын газрын 2018 оны ажлын төлөвлөгөөнд үндэслэн “Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдалд” хийсэн нийцлийн аудитын тайланг хүлээн авч танилцлаа.

Тайлангийн төсөлтэй танилцаад дараах санал, ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

1. Нийцлийн аудитаар гарсан үр дүнг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд энд гарсан алдаа дутагдлыг цаашид дахин гаргахгүй байх тал дээр хариуцсан албан тушаалтан бүр ажилдаа анхаарч, жил бүр дотоод хяналтаар хяналт, үнэлгээ дүгнэлт хийж ажиллаж байхаар шийдвэрлэлээ.
2. 2018 оны тэтгэмжид олгогдохоор нэр орсон боловч аудитаар 2019 онд тэтгэмжээ авах нэр бүхий 26 хүний 83,0 сая төгрөгийн тэтгэмжийн залруулан тооцсон.
3. Аудитаар тогтоогдсон актын биелэлтийг барагдуулах талаар тухайн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч, тэтгэмж авсан иргэн, албан тушаалтнууд санаачлагатай ажиллаж бүрэн барагдуулах чиглэлийг албан бичгээр байгууллагуудад хүргүүлэх
4. Боловсролын хуулийн дагуу олгогдох тэтгэмжийн мэдээллийн санг шинэчлэн өөрчлөлт орсон тухай бүрд баяжуулалт хийж байх
5. 2018 оны 11-р сарын 12-нд Боловсрол, соёл, урлагийн газар дээр болох захирал, эрхлэгч нарын сургалтын үед аудит хийсэн аудиторыг иргүүлэн нийцлийн аудитын тайлан, үр дүн, цаашид анхаарах чиглэлийн талаар мэдээлэл хийж өгөхийг хүсэе. /Мэдээллийг бодит болгох, хяналт сайн тавих, нэр орхигдох, хувь хүн багш нарын хариуцлагыг сайжруулах талаар гэх мэт/
6. Нийцлийн аждитын тайланд Боловсрол, соёл, урлагийн газрын төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэний ажил үүргийн чиглэлээр тодорхой зөвлөмж өгөх талаар оруулж өгнө үү. /Ажлын ачаалал, байгууллагын тоо, хүүхдийн тоо, багшийн тооноос хамаарсан тооцоо судалгаа их байгаа, хөрөнгө оруулалт, дотоод хяналтын ажлуудын үүргийг хэрхэн гүйцэтгэх гэх мэт/

ДАРГА Я.ДАШЗЭВЭГ

ХУУЛБАР ҮНЭН
Гарын үсэг
2018 он 11 сар 12 өдөр

| | |
|---|---|
| Санал-7<br><br>*Хавсралтыг тайлангаас хасаж, тайлангийн дүнд оруулав.* | ХӨВСГӨЛ АЙМГИЙН<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР<br>67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг<br>Эрүүл мэндийн газрын байр Утас: 70382496<br>Э-майл: khuvsgul.emg@gmail.com<br>2018.11.06 № 1064<br>танай ______ -ны № ______ -т<br><br>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ<br>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ<br><br>Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдалд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>1. Төлөвлөлт болон гүйцэтгэл мэдээллийн санг тухай бүр шинэчлэн хяналт тавьж ажиллах болно.<br>2. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасны дагуу төсвийг эрүүл мэндийн байгууллага бүрээр тусгаж авах саналыг Эрүүл мэндийн яаманд давхар уламжилж өгөх шаардлагатай байна. /Эрүүл мэндийн яам нэгдсэн хяналт алдагдана гэж үзээд байгууллага бүрээр төсөв авдаггүй/<br>3. Хавсралт №7-д заасан дүн /652.3/ манайд ирүүлсэн 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн ХӨА-2018/01/НА-1/16 дугаартай актын дүн /330.6/ зөрүүтэй байна. /Тайлбар ирүүлнэ үү?/<br>Хамтарч ажилласан та бүхэнд баярлалаа.<br><br>ДАРГА М.ҮҮРИЙНБАЯР<br>D:\HP\alban bichig\2018-A5.docx |

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**
**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,**
**АУДИТЫН АЛБА**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг,
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар, Утас: 7038 3934
Э-майл: sankhuu_audit_hu@yahoo.com

2018.11.07 № 1/170.
танай 2018.11.05 -ны № 04/703 -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН**
**ДАРГА О.ГАНБОЛД ТАНАА**

Танай байгуулагаас ирсэн “Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдал”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА Л.В.НЭРГҮЙ

PIOA0057 8156379

Л.[illegible]
Санал. [illegible]
танилцаж тайлан
хавсаргав
[illegible]

| | |
|---|---|
| Санал-8<br><br>*Тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй* | СХАА-ны 2018 оны 11 дүгээр сарын 07-ны<br>1/170 тоотын Хавсралт..1<br><br>**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**<br><br>Санал хүргүүлэх тухай. Мөрөн<br><br>Танай байгууллагаас ирүүлсэн “Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдал” хийсэн нийцлийн аудитын төсөлтэй танилцлаа.<br><br>Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2017-2018 онд Түнэл, Тосонцэнгэл, Рашаант, Чандмань Өндөр, Рэнчинлхүмбэ, Тариалан, Эрдэнэбулган, Хатгал, Алаг Эрдэнэ, сумдад санхүүгийн хяналт, нийцлийн аудит, 2017 онд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Боловсрол соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газартай хамтарсан нэгдсэн хяналтыг өөрсдийн чиглэлийг баримтлан гүйцэтгэсэн билээ. Төлөвлөгөөт шалгалтаар хийж гүйцэтгэхдээ тухайн сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний бүх байгууллагыг хянан шалгадаг бөгөөд зөрчил, асуудал илрүүлэлтийн хувьд хангалттай хэмжээнд гүйцэтгэж байгаа үзэж байна.<br><br>Манай алба нь Сангийн яамны Санхүүгийн хяналт, Эрсдэлийн удирдлагын газартай зөвшилцөж, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн Дотоод аудитын хорооны даргаар батлуулан санхүүгийн хяналт, нийцлийн аудит гүйцэтгэдэг бөгөөд бидний ажилд дараах асуудлууд тулгардаг болно.<br><br>1. Танай байгууллагын төлөвлөгөөт аудит, манай байгууллагын төлөвлөгөөт санхүүгийн хяналт, нийцлийн аудит цаг хугацааны зөрүүтэй байдаг.<br>2. Бид жилийн ажлын төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтонд сэдэвчилсэн санхүүгийн хяналт, нийцлийн аудитын ажлыг төлөвлөөгүй.<br>3. Тусгай шилжүүлэгийн байгууллага болох Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар нь өөрсдийн чиг үүргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд хамаарагддаг бөгөөд тухайн салбарын төрийн албан хаагчдад олгож буй нэг удаагийн тэтгэмжийн төлөвлөлт гүйцэтгэлд 2017-2018 онд санхүүгийн хяналт, нийцлийн аудитын ажлыг гүйцэтгээгүй болно.<br><br>Танай нийцлийн аудитын багаас өгч буй зөвлөмжийн дагуу эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн 2019 оны аудитын жилийн төлөвлөгөөнд тусган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг эрсдэлээс хамгаалан ажиллах болно.<br><br>ТАЙЛБАР БИЧСЭН:<br>САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ<br>ДОТООД АУДИТОР О.АМАРСАЙХАН |

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

**Санал-1**. Хүлээж авах боломжгүй.

**Санал-2.** Тайлангийн 1.3-т өөрчлөлт оруулав.

**Санал-3,4,5,8-д** Тайлангийн дүнд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

**Санал-6** Төсвийн мэргэжилтний ажлын байрны талаар Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй. 2018 оны 11 дүгээр сарын 12-нд боловсролын байгууллагын дарга, эрхлэгч нарын сургалтын үеэр аудитор Э.Бат-Эрдэнэ, С.Гансүх нар тэтгэмжийн аудитын талаар мэдээлэл өгсөн.

**Санал-7** Хавсралтыг тайлангаас хасаж, тайлангийн дүнд  оруулав.

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 28 өдөр  Дугаар А/56  Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдал”-д хийсэн нийцлийн аудитын тайланг батлалсугай.

2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, аудитын алба, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2019 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг дарга (Л.Ганболд), Боловсрол, соёл урлагийн газрын дарга (Я.Дашдэвэг), Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (В.Нэргүй), сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5. Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг), нийцлийн аудитын албаны ахлах аудитор (Л.Энх-Амгалан) нарт даалгасугай.

6. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг нийцлийн аудитын албаны ахлах аудитор (Л.Энх-Амгалан), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.ГАНБОЛД

Data:tushaal2018

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны 11 дүгээр сарын ..... -ны өдрийн .........тоот тушаалын хавсралт

Акт, албан шаардлагын жагсаалт

/сая.төгрөгөөр/

| № | Дугаар | Зөрчлийн утга | Мөнгөн дүн |
|---|---|---|---|
| А | Төлбөрийн акт | | |
| 1 | ХӨА-2018/01/-НА-01/16 | Эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд 0.3 сая төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон | *0.3* |
| 2 | ХӨА-2018/01/-НА-03/19 | Хатгал тосгоны СӨБ-ийн няравт нэг удаагийн буцалтгүй тусламж олгосноос 2.8 сая төгрөгийг илүү олгосон байна. | *2.8* |
| 3 | ХӨА-2018/01/-НА-02/18 | Боловсролын тухай хуулийн 43.1.7 дахь заалтыг зөрчин Тосонцэнгэл сумын ЕБС-ийн сургалтын менежер Ц.Пүрэвдоржид 2019 онд олгох 1,706.9 мянган төгрөгийн тэтгэмжийг 2017 онд олгосон байна. | *1.7* |
| 4 | ХӨА-2018/01/-НА-04/20 | 2012 онд Галт сумын ЕБС-ийн дотуур байрын багш М.Батсайхан /1.8 сая төгрөг/, М.Оюунгэрэл /1.8 сая төгрөг/ нарт Боловсролын тухай хуулийн 43.1.7-ийн 43.1.7.а заалтыг зөрчиж тэтгэмж олгосон | *3.6* |
| 5 | ХӨА-2018/01/-НА-05/21 | Ханх сумын ЕБС-ийн сургалтын менежер Б.Содгэрэлд 2014 онд 3.2 сая төгрөг, 2016 онд 3.2 сая төгрөгийг тус тус олгосон байна. Үүнээс 3.2 сая төгрөг илүү олгогдсон байна. | *3.2* |
| Б | Албан шаардлага | | |
| 1 | ХӨА-2018/01/-НА-01/31 | Эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд олгож байгаа мөнгөн тэтгэмжийг олгохдоо нэг сарын үндсэн цалинг үндэслэлгүй тооцож олгосон 1.2 сая, шалгуур хангаагүй ТАХ-д хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох 23.2 сая, 12.5 сая төгрөгийн тэтгэмжийг олгохоор төлөвлөсөн. | *36.9* |
| 2 | ХӨА-2018/01/-НА-02/42 | Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7.а заалт дахь албан тушаалтай */2014 онд тэтгэмж авсан/* 26 хүнд нийт 83.0 сая төгрөгийг 2018 онд олгохоор төлөвлөн төсөвт суулгасан | *83.0* |
| 3 | ХӨА-2018/01/-НА-03/48 | Хариуцлага тооцох албан шаардлага | Мөнгөн бус |
| | | Дүн | *131,5* |

___ооОоо___

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, УранДөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38 37-93
Э-майл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.22 № ХАА-2018/01/-НА-03/48

АЙМГИЙН БОЛОВСРОЛ СОЁЛ
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
З.ДАШЗЭВЭГ ТАНАА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлын олголтын байдал"-д хийсэн нийцлийн аудит, "Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн" санхүүгийн аудитаар Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын төсвийн төлөвлөлт, төсвийн хуваарь, төсвийн хяналттай холбоотой нийт 185,818,750 /Нэг зуун наян таван сая найман зуун арван найман мянга долоон зуун тавин/ төгрөгийн зөрчил илэрсэн болно.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42.5-д (Төсвийн тухай хуулийн 42.5.Энэ хуулийн 15.2-т заасан төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийн төсөвт зохицуулалт хийх асуудлыг өөрийн баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ.) ", Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д (Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгоно), Боловсролын тухай хуулийн 43.7 дахь хэсэгт "Энэ хуулийн 43.1.4, 43.5-д заасан нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно" гэсэн заалтуудыг зөрчсөнтэй холбоотой байна.

Дээрх зөрчил нь Боловсрол, соёл, урлагийн газрын Төсөв, хөрөнгө хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Далайжаргал ажлын чиг үүрэг, хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй байдлаас шалтгаалсан байна.

Иймд: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28,1-д (Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Боловсрол соёл урлагийн газрын Төсөв хөрөнгө хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Далайжаргалд холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 03-ны дотор Хөвсгөл

1551421



аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Я.Дашзэвэгт даалгав

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Л.Энх-Амгалан

Аудитор С.Гансүх

Хянасан:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер
Ж.Отгончимэг XI/22

**ЗӨВШӨӨРСӨН:**

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Я.Дашзэвэг

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*